

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



2024 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2024-06

Улаанбаатар хот

ХасБанк ХК-ийн Ногдол ашгийн бодлогод  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

ХасБанк ХК (“Банк”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд дараах шийдвэрийг гаргав:

## ТЭМДЭГЛЭХ нь:

- Банкны хувьцаа эзэмшигчид өмнө нь ХасБанк ХК-ийн Ногдол ашгийн бодлогыг SR-2024-01 дугаартай тогтоолоор баталсан болохыг (“Ногдол ашгийн бодлого”);
- Санхүүгийн Зохицуулах Хороо (“СЗХ”) нь 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” 28 дугаар тогтоолдоо өөрчлөлт оруулж, нээлттэй хувьцаат компаниуд ногдол ашгаа санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор хувьцаа эзэмшигчдэд тараах, ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор СЗХ-нд ирүүлэхийг үүрэг болгосныг;
- СЗХ нь 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 3/712 тоот албан бичгээрээ ногдол ашиг хуваарилах, тайлагнахтай холбогдуулан 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 49 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Банкнд үүрэг болгосныг;
- СЗХ-ны тогтоосон журмыг дагаж мөрдөх зорилгоор Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн R-2024-18 дугаар тогтоолоор зөвлөмж болгосны дагуу Хувьцаа эзэмшигчид нь Ногдол ашгийн бодлогод өөрчлөлт оруулахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

## ТОГТООХ нь:

- Дээрхийг үндэслэн, Ногдол ашгийн бодлогын 3.2, 3.3 болон 4.1 дүгээр хэсгүүдэд дараах өөрчлөлт, нэмэлт өөрчлөлтийг оруулсугай:

Одоогийн заалт	Нэмэлт өөрчлөлт оруулсан заалт
3.2 Компанийн тухай хуульд заасны дагуу Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хагас жилийн ногдол ашиг хуваарилах эсэхийг оны	3.2 Компанийн тухай хуульд заасны дагуу Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хагас жилийн ногдол ашиг хуваарилах эсэхийг оны

<p>эхний хагас жил дууссанаас хойш 120 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ. Ногдол ашиг хуваарилах эсэхийг зарлах, ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.</p> <p>3.3 Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн шийдвэрлэж, Хувьцаа эзэмшигчдийн баталснаар ногдол ашиг авах эрхтэй.</p> <p>4.1 Банк нь тухайн санхүүгийн жилийн санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны хэтийн төлөв, үйл ажиллагаа цаашид өргөжин тэлэх боломжид үндэслэн нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг энэхүү бодлогын 3.2-т заасан эрх бүхий этгээд хэлэлцэн шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчид эцэслэн шийдвэрлэнэ.</p>	<p>эхний хагас жил дууссанаас хойш 120 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ. <del>Ногдол ашиг хуваарилах эсэхийг зарлах, ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.</del></p> <p>3.3 Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн <u>шийдвэрлэснээр шийдвэрлэж, Хувьцаа эзэмшигчдийн баталснаар</u> ногдол ашиг авах эрхтэй.</p> <p>4.1 Банк нь тухайн санхүүгийн жилийн санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны хэтийн төлөв, үйл ажиллагаа цаашид өргөжин тэлэх боломжид үндэслэн нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг энэхүү бодлогын 3.2-т заасан эрх бүхий этгээд хэлэлцэн <u>шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчид эцэслэн шийдвэрлэнэ шийдвэрлэнэ.</u></p>
---	---

2. Ногдол ашгийн бодлогод дээр дурдсан өөрчлөлт, нэмэлт өөрчлөлтийг тусган, энэхүү тогтоолд хавсаргасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА